

Монгол Улсын Засгийн Газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоолын хэрэгжилттэй холбоотой хийсэн дотоод хяналт шалгалтын ажлын тайлан

Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэж заасны дагуу тогтоолын хэрэгжилтийг Засгийн газрын II байр (А,Б,В,Г,Д,Е корпус), III, IV, VIII, IX “А”, IX “Б”, XI, XII, АМГТГ, XIII байруудад 2021 оны 04 дүгээр сарын 02,03-ны өдрүүдийн ажлын бус цагаар (21:00 цагаас хойш) хяналтын ажлыг хийж гүйцэтгэлээ.





Энэхүү хяналт шалгалтын ажлын зорилго нь харьяа байруудын давхар бүрийн албан өрөө тасалгаа, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөөнүүдэд цахилгаан эрчим хүч, гэрэл үр ашиггүй ажиллаж буйг үзэж шалган унтрааж, эрчим хүч, цахилгаан зарцуулалтын урсгал зардлыг бууруулан хэмнэх зорилготой байв.

Хяналт шалгалтын ажлаар харьяа байруудад дараах асуудлуудыг илрүүллээ.

Үүнд:

1. Засгийн газрын II байр


№	Харьяа байр	Давхар	Зураг
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (22:05 минутанд эхэлсэн)	I давхрын эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөний гэрэл асаалттай байв.	
		III давхрын нийтийн эзэмшлийн талбайн гэрэл асаалттай байв.	

		III давхрын нийтийн эзэмшлийн талбайн гэрэл асаалттай байв. Мөн IX, X давхрын шатны гэрэл асаалттай байв.	
2	Үндэсний хөгжлийн газар	201 тоот өрөөний гэрэл асаалттай үлдсэн байв.	
3	УУХҮЯ	II, III давхрын нийтийн эзэмшлийн талбайн гэрэл асаалттай байв. (бүдэгхэн гэрэл асдаг)	
4	Сангийн яам	IX, X давхрын нийтийн эзэмшлийн талбайн гэрэл асаалттай байв. VII, VIII давхрын ариун цэврийн өрөөний гэрэл асаалттай байв. V давхрын лефтний үүдний гэрэл, IV давхрын ханын гэрэл асаалттай байв.	
5	БОАЖЯ	II давхрын зүүн жигүүрийн нийтийн эзэмшлийн талбай, III давхрын баруун жигүүрийн нийтийн эзэмшлийн талбай болон эрэгтэй ариун цэврийн өрөөний гэрэл асаалттай байв. Мөн I давхрын баруун, зүүн жигүүрийн нийтийн эзэмшлийн талбайн гэрэл асаалттай байв.	

2. Засгийн газрын III байр (БШУЯ, ҮСХ)

№	Харьяа байр	Давхар	Зураг
1	БШУЯ (22:55 минутанд эхлэв)	V давхрын нийтийн эзэмшлийн талбайн гэрэл, ариун цэврийн өрөөний гэрэл асаалттай байв. III, IV давхрын нийтийн эзэмшлийн талбайн гэрэл асаалттай байв.	
2	Үндэсний статистикийн хороо	II давхрын нийтийн эзэмшлийн талбай, эмэгтэй ариун цэврийн өрөөний гэрэл асаалттай байв.	

3. Засгийн газрын IV байр (Үндэсний аудитын газар, Санхүүгийн зохицуулах хороо)

№	Харьяа байр	Давхар	Зураг
1	Үндэсний Аудитын Газар (21:30 минутанд эхлэв)	Үндэсний аудитын газрын II давхрын нийтийн эзэмшлийн талбай болон 304 тоот өрөөний гэрэл асаалттай байв.	
2	Санхүүгийн зохицуулах хороо	Санхүүгий зохицуулах хорооны 402 тоот хурлын танхимын гэрэл асаалттай байв.	


4. Засгийн газрын IX “А”, IX “Б” байрууд


№	Харьяа байр	Давхар	Зураг
1	<p>Засгийн газрын IX “А” байр (20:45 минутанд эхлэв)</p>	<p>I давхрын эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөний гэрэл болон угаалгын өрөө, мужааны өрөөний гэрэл асаалттай байв. II давхрын урт талын нийтийн эзэмшлийн талбай болон ариун цэврийн өрөөний гэрэл асаалттай байв.</p>	
2	<p>Засгийн газрын IX “Б” байр</p>	<p>I давхрын хурлын заалны гэрэл асаалттай байв.</p>	

5. Засгийн газрын XI байр

№	Харьяа байр	Давхар	Зураг
1	ЗГ-ын XI байр	<p>XI, XII давхрын эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөний гэрэл асаалттай байв.</p> <p>Мөн VIII, IX давхрын нийтийн эзэмшлийн талбай болон эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөний гэрэл, 905 тоот өрөөний гэрэл асаалттай байв. IV, V, VI, VII давхрын эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөний гэрэл асаалттай байв.</p> <p>III, IV давхрын нийтийн эзэмшлийн талбай, эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөний гэрэл асаалттай байв.</p>	 

6. Засгийн газрын XII байр

№	Харьяа байр	Давхар	Зураг
1	БХБЯ, ГЗБЗЗГ (22:30 минутанд эхлэв)	<p>IV давхрын нийтийн эзэмшлийн талбай, эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөний гэрэл асаалттай байв.</p> <p>II давхрын нийтийн эзэмшлийн талбайн гэрэл асаалттай байв.</p> <p>Мөн МХЕГ-ын ариун цэврийн өрөөний гэрэл асаалттай, I, II, III, IV давхруудын шатны гэрэл асаалттай байв.</p>	



Тус хяналт шалгалтын ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 02,03-ны өдрүүдийн ажлын бус цагаар (21:00 цагаас хойш) хийж гүйцэтгэлээ. Харьяа байруудад ажилладаг үйлчлэгч нар нь албан өрөө тасалгаа, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөөнүүдийг тус тус цэвэрлэж гүйцэтгэсний дараа гэрэлтүүлгийг унтраан, хянамгай ажиллагааг (анхаарч, шалгаж байх) сайжруулснаар цахилгааны төлбөрийг бууруулах давуу талтай болно.

Мөн үйлчлэгч албан өрөө тасалгаанд цэвэрлэгээг хийж гүйцэтгэхэд тухайн өрөөнд ажиллаж буй албан хаагчдын өрөө тасалгааны тоотыг Төрийн тусгай, харуул хамгаалалтын ажилтанд түлхүүрийг лацдаж хүлээлгэн өгөхдөө бүртгэлжүүлэх ажлыг сайжруулах хэрэгтэй нь харагдсан. Ингэснээр тухайн ашиглагдаагүй гэрэл, цахилгааныг (Ариун цэврийн өрөө, Нийтийн эзэмшлийн талбай, Албан өрөө тасалгаа) унтраах эзэнтэй болж улмаар урсгал зардал, цахилгааны хэрэглээнд хэмнэлж хийж, зардлыг бууруулах боломжтой байна.

Энэхүү ажлыг байгууллагын үйл ажиллагаанд зөвлөн, туслах чиглэлээр хийж гүйцэтгэлээ.

Цаашид ус болон дулааны ухаалаг, зохистой хэрэглээнд хяналт шалгалт хийх нь зүйтэй гэж үзсэн болно.

Хяналт шалгалт хийсэн:

Дотоод аудит, хяналт
үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Г.Бямбацогт